

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН АНГИ, БАЙГУУЛЛАГЫН
2021 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

 Хагас жилийн байдлаар

№	Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ
<i>Зорилт-1: Хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр</i>			
1.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэх.	<p>Цагдаагийн ерөнхий газраас 196.230 дагагч бүхий албан ёсны пэйж хуудсаар дамжуулан Авлигатай тэмцэх газрын олон нийтийн төв болон Авлигатай тэмцэх газрын албан ёсны пэйж хуудаснаас мэдээ, мэдээллийг эх сурвалжийг нь заан хуулбарлан авч, иргэд, олон нийтэд цахимаар хүргэх ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Энэ оны эхний хагас жилийн байдлаар Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн пэйж хуудсанд авлига, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх утга агуулга бүхий постер-13, мэдээ, мэдээлэл-7, “Төрийн албан хаагч танаа”, “Энхрий үрс бүхэн шударга хүн болоосой”, “Зөв зөвд, шударга зөв” зэрэг видео шторк-8, нийт 28 мэдээлэл байршуулсан нь 896.241 хүнд хүрч, 285 удаа бусадтай хуваалцсан үзүүлэлттэй байна.</p> <p>Улаанбаатар хотод байрлах лед болон урсдаг зарын дэлгэцүүдийн судалгааг дүүрэг нэг бүрээр гаргаж, 9 байршилд, орон нутагт Архангай, Баянхонгор аймаг дахь цагдаагийн газраас лед дэлгэцээр Авлигын эсрэг постер, мэдээллийг байршуулж, иргэд, олон нийтэд хүргэсэн.</p>
		1.2. Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах.	Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтэд авлигын хор аюулыг ухуулан таниулах, олон нийтийг авлигатай тэмцэх арга барилд сургах, тэднийг татан оролцуулах хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс улсын хэмжээнд цахимаар зохион байгуулсан “Зөв зөвд шударга зөв” аяны мэдээлэл, подкаст, ведио шторк, “GOOD HABITS-21” буюу “Зөв дадал-21” дижитал чуулганы мэдээллийг харьяа нэгжүүд сайтад байршуулан иргэд, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан.
		1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах.	Цагдаа, дотоодын цэргийн 61 анги, байгууллага “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг ажиллуулж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг

			зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг цахим хуудас, фэйсбүүк хаяг болон “Ухаалаг дэлгэц”-д байршуулж иргэд олон нийтэд сурталчилж байна.
Зорилт-2: Авлигын эсрэг сургалт зохион байгуулах чиглэлээр			
2.	Албан хаагчдыг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах сургалтад хамруулах	2.2. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулах.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг цахимаар тайлагнах ажлын хүрээнд санд мэдээлэл оруулах, биелэлтийг тооцох, арга зүйн зөвлөмж мэдээллээр хангах, ХАСХОМ бүрдүүлэлтийн программын ашиглалттай холбоотой цахим санд мэдээллийг үнэн зөв оруулах, хяналт тавих, анхаарах асуудлын чиглэлээр зохион байгуулсан цахим сургалтад тус тус алба хаагчид хамрагдсан.
		2.3. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдад хүргэх, шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнах.	Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2021 оны А/02 тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-г баталж, энэ оны эхний 5 сарын байдлаар 14 анги байгууллага “Авлигын эсрэг хууль тогтоомж”, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” зэрэг сэдвээр нийт 1578 алба хаагчдад цахимаар болон танхимын сургалт зохион байгуулж ажилласан байна.
Зорилт-3: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр			
3.	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх	3.1. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн “Зөвлөмж”-ийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах.	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээнээс Монгол Улсын Авлигын эсрэг эрх зүйн орчин, төрийн байгууллагуудын авлигатай тэмцэх үйл ажиллагаанд мониторинг хийсэн зөвлөмжийн цагдаагийн байгууллагад хамаарах 6 зорилт, 25 ажил арга хэмжээний хэрэгжилтийг энэ оны эхний 5 сарын байдлаар /88.8 хувь/ тооцон үнэлж, Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.
		3.2. Мөрдөгчийн мэдэгдлийн дагуу арга хэмжээ зохион байгуулж, хуулийн хугацаанд хариу хүргүүлэх.	Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах тухай мөрдөгчийн мэдэгдэл ирүүлснийг харьяалах газар, хэлтэст албан бичгээр хүргүүлж, мэдэгдлийн мөрөөр урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулж, хариуг тухай бүр нотломжийн хамт хүргүүлэн хяналт тавин ажилласан.
		3.3. Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах.	Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр ирүүлсэн 04 тоот “Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах тухай” мөрдөгчийн мэдэгдэл ирүүлснийг цагдаа, дотоодын цэргийн бүх анги байгууллагууд руу албан бичгээр хүргүүлэн Цагдаагийн байгууллагын удирдлагын цогц систем /eoffice.police.gov/-ын Олон нийт цэсийн Зар мэдээ хэсэгт байршуулан алба хаагч нарт танилцуулж, сургалт зохион байгуулсан.

			<p>Тухайлбал: Мөрдөн байцаах албаны хэлтэс, тасаг, хэсгийн мөрдөгчдийн хууль, эрх зүйн мэдлэгийн түвшинг тогтоох, хууль хэрэглэх чадварыг сайжруулах зорилгоор Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургууль, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын Хуульчдын холбоотой хамтран Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор тестийн сорилыг боловсруулж, байгууллагын сургалтын нэгдсэн систем http://testserver.police.gov/-ыг ашиглан энэ оны 01 дүгээр сарын 29-ний өдөр шалгалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 1155 алба хаагчийг хамруулсан.</p>
		<p>3.4. Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулж, төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах боломжийг бүрдүүлэх.</p>	<p>Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу дараах захиргааны хэм хэмжээний актын төслийг цагдаагийн байгууллагын цахим хуудсанд 30-аас доошгүй хоногийн хугацаанд байрлуулж, санал авах ажлыг зохион байгуулсан: Үүнд</p> <p>- “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”-ын төсөл, “Санал авах байранд байрлуулах хяналтын камерт тавигдах шаардлага, түүнийг байрлуулах, ашиглах болон бичлэгийг хадгалах, хамгаалах, устгах журам”-ын төсөл, “Халдвар авсан иргэний хөдөлгөөнийг тогтоох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авах журам”-ын төсөл, “Цар тахлын үед Засгийн газар, төрийн бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй цар тахлын хүрээг тогтоохтой холбоотой тоон мэдээ, мэдээллийг шуурхай солилцох журам”-ын төслийг тус тус Цагдаагийн ерөнхий газрын цахим хуудас www.police.gov.mn/-ны “Хууль, эрх зүй” цэсний “Хэлэлцүүлэг” дэд цэсэнд байршуулж ажилласан.</p>
Зорилт-4 : Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр			
4.	<p>Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх</p>	<p>4.1. Цагдаагийн байгууллагын хэмжээнд авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг батлуулах.</p>	<p>Цагдаа, дотоодын цэргийн 2021 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Авлигатай тэмцэх газраас 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01/696 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмж, байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, ил тод, нээлттэй байдлыг хангах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн 6 зорилт, 51 заалтын хүрээнд боловсруулан батлуулж, 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдөр 3/53 дугаар албан бичгээр харьяа нэгжүүдэд хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>
	<p>Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл</p>	<p>4.4. Цагдаагийн байгууллагын хэмжээнд Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны</p>	<p>Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг байгууллагын</p>

	<p>эрмэлзэл, санаачилга өрнүүлэх</p>	<p>төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг байгууллагын 2022 оны төсөвт тусгуулах санал хүргүүлэх.</p> <p>4.5. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.</p>	<p>2022 оны нэгдсэн төсөвт тусгуулахаар саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлээ.</p> <p>ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсгийн дагуу тендерийн үнэлгээний хороонд хоёроос доошгүй хөндлөнгийн төлөөлөгч оролцуулж, хөндлөнгийн хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэн, 24 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим систем www.shilendans.gov.mn болон байгууллагын цахим хуудас www.police.gov.mn, мэдээллийн самбарт хуулийн хугацаанд тухай бүр байршуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.</p>
<p>Зорилт-5: Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах чиглэлээр</p>			
<p>5.</p>	<p>Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх</p>	<p>5.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/</p>	<p>“Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-өөр цагдаагийн байгууллагаас лавлагаа гаргахтай холбоотойгоор тус албанаас галт зэвсэг, жолоочийн лавлагаа, ял шийтгэлийн мэдээллийн сангийн хуулбар мэдээллийн санг “Үндэсний дата төв” УТҮГ-т байрлах сервер дээр байршуулж, лавлагаа авах мэдээллийн өгөгдлийн сангаас хэрхэн авч, гаргах талаар зааварчилгаа, SQL-ийг бэлтгэн Үндэсний дата төвд хүргүүлж, гарч байгаа асуудлынэ талаар тухай бүр хариу өгч ажиллаж байна.</p> <p>Төрийн үйлчилгээний портал систем /e-mongolia.gov.mn/-ийн “Жолоодох эрх, тээврийн хэрэгсэл” хэсгээс “Жолоодох эрхийн лавлагаа”, “Жолоочийн лавлагаа, мэдээлэл”-ийг, “Зөвшөөрөл тодорхойлолт, дүгнэлт акт” хэсгийн “Тусгай зөвшөөрөл”-өөс “Галт зэвсэг эзэмших өмчлөх эрхийн лавлагаа”-г, “Хууль сахилт” хэсгээс “Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт”, “Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт”, “Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт”, “Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт”-ийг тус тус авах боломжийг бүрдүүлсэн.</p>
<p>Зорилт-6: Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр</p>			
<p>6.</p>	<p>Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх</p>	<p>6.1. Тухайн жилийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллэх.</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/212, 2021 оны А/54 дүгээр /тодотгол/ тушаалаар “Хууль зүй дотоод хэргийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөө”-г баталсан.</p> <p>Төлөвлөгөөний нэгдүгээр хавсралтаар “Төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас худалдан авах төсөл арга хэмжээний зардалд нийт 8.4 тэрбум тусганаас барилга байгууламж шинээр барих 6.1 тэрбум, барилгыг өргөтөл, урсгал болон их засварт зарцуулах 2.0</p>

			<p>тэрбум, тоног төхөөрөмж худалдан авах 312.0 сая төгрөгийн нийт 33 /давхардсан тоогоор/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийн урилга, үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn, www.police.gov.mn, www.shilendans.gov.mn-нд байршуулж, өдөр тутмын сонин хэвлэлд мэдээлсэн.</p>
		6.2. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг цахим хуудсанд байршуулах.	<p>Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх хэсэгт заасны дагуу 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор shilendans.gov.mn сайт болон байгууллагын цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Байршуулсан мэдээллийн статистик үзүүлэлт, хэрэгжилтийн байдлыг нэгтгэн үзэхэд энэ төрлийн мэдээллийг 2020 оны IV улиралд 53 нэгж хугацаандаа 100 хувь бүрэн оруулсан байна.</p>
		6.3. Дараа жилийн төсвийн төсөл /8 дугаар сарын 15-ны дотор/ цахим хуудсанд байршуулах.	<p>Цагдаагийн байгууллагын 2021 оны төсвийн төслийн мэдээллийг Санхүү, аж ахуйн албаны даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн систем www.police.gov.mn сайтад 2020 оны 08 дугаар сарын 15-ны дотор байршуулсан.</p>
		6.4. Жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудсанд байршуулах.	<p>Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг www.shilendans.gov.mn сайт болон байгууллагын цахим хуудсанд байршуулсан.</p>
		6.5. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудсанд байршуулж, аудитын байгууллагын акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллах, нэгжүүдийг мэдээллээр бүрэн хангах.	<p>Цагдаа, дотоодын цэргийн 54 анги, байгууллагын 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн аудитын шалгалт явагдаж, нэгтгэсэн санхүүгийн тайлан болон Нийслэл, орон нутгийн 35 байгууллага “Зөрчилгүй” санал дүгнэлттэй шалгагдсан.</p> <p>Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн аудитын шалгалтаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг нэгтгэн Санхүү, аж ахуйн албаны энэ оны 1 дүгээр улирлын тайлангийн хурлаар төсөв захирагч, санхүүгийн алба хаагчдын танилцуулж, зөвлөгөө өгөн, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган цаашид анхаарах асуудлаар зөвлөмж боловсруулж, энэ оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 6/742 дугаар албан бичгээр харьяа нэгжүүдэд хүргүүлээ.</p>
Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх заалт			
7.	Шилэн данс болон цахим хуудсаар олон нийтэд мэдээлэл өгөх	7.1. Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх, /өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт/ цахим хуудсанд байршуулах.	<p>Монгол Улсын Их Хурлаас баталсан төсвийг 01 дүгээр сарын 08-ны дотор, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалын дагуу өөрчлөлт орсон төсвийг өөрчлөлт орсон сар бүрийн 08-ны дотор police.gov.mn сайтад байршуулан нийтэд мэдээлж байна.</p>

	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	7.2. Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох. /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/	Цагдаагийн ерөнхий газраас 5 сая төгрөгөөс дээш ажил, үйлчилгээний гүйлгээг байгууллагын шилэн дансны гүйлгээний хэсэгт, Хууль зүй, дотоод хэргийн яамны шилэн дансны улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл хэсэгт мэдээллийг тухай бүр байршуулж байна.
		7.3. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан.	Монгол Улсад Коронавируст /Ковид-19/ халдварын цар тахлын нөхцөл байдал хүндэрч бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотой хорио цээрийн дэглэм сахиулах хамгаалалтад ажилласан цагдаа дотоодын цэргийн анги байгууллага, албан хаагчдад Улсын онцгой комисс, Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Монгол цэргийн нэгдсэн холбоо, БНСУ дахь Монгол оюутны холбоо ТББ, аж ахуйн нэгж, иргэдээс нийт 34,7 сая төгрөгийн хандивыг ирүүлсэн. Хандив тусламжаар ирсэн бараа материалуудыг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага нэгжүүдэд хуваариарлан тараан олгож, цалингийн зардлаас бусад орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр хаягийн хамт шилэн дансны тухай бүр мэдээлэх хуудсанд сар бүрийн 08-ны өдрийн дотор нийт 5 удаа хуулийн хугацаанд мэдээлэн ажилласан.
		7.4. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт мэдээлэх.	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний орлогын 18,9 тэрбум төгрөг, зарлагын 11,9 тэрбум төгрөгийн 140 удаагийн гүйлгээг агуулга, хүлээн авагчийн нэр, гүйлгээний утгаар мэдээлж ажилласан.
		7.5. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлэх.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн талаар 243 удаагийн мэдээлэл хүргэж ажиллалаа.
<i>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалт</i>			
8.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,	8.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/212 дугаар тушаалаар Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын “Худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөө”-г баталсан. Тус төлөвлөгөөний нэгдүгээр хавсралтаар хөрөнгө оруулалтад 8.3 тэрбум, хоёрдугаар хавсралтаар урсгал төсөвт 21.0 тэрбум төгрөг тус тус батлагдаж, худалдан авах ажиллагааны “www.tender.gov.mn” цахим системд байршуулсан.

ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	8.2. Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга.	“Худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх /давхардсан тоогоор/ нийт 33 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн урилга, үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn , www.police.gov.mn , www.shilendans.gov.mn -нд болон өдөр тутмын сонин хэвлэлд холбогдох хууль, журмын дагуу байршуулж, олон нийтэд ил тод мэдээлэн ажиллаж байна.
	8.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл/	Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн 33 багц төсөл арга хэмжээнд давхардсан тоогоор 841 аж ахуйн нэгж байгууллага оролцсон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27, 28 дугаар зүйлд заасныг баримтлан хянан үзэж, үнэлэн мөн давхардсан тоогоор 88 аж ахуйн нэгж байгууллага шалгаран гэрээ байгуулагдаж үр дүнг тухай бүр нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn , shilendans.gov.mn холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байршуулж, олон нийтэд ил тод мэдээлэн ажилласан.
	8.4. Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлан.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/212 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөө”-ний нэгдүгээр хавсралтад хөрөнгө оруулалт 8.4 тэрбум төгрөг тусгагдсанаас 6.1 тэрбум төгрөг буюу 72 хувийн гүйцэтгэлтэй, хоёрдугаар хавсралтад урсгал төсөвт 21.1 тэрбум төгрөг тусгагдсанаас 16.4 тэрбум төгрөг буюу 77 хувийн гүйцэтгэлтэй байна.
	8.5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүн.	Байгууллагын 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн аудитын шалгалт явагдаж, нэгтгэсэн санхүүгийн тайлан болон Нийслэл, орон нутгийн 35 байгууллага “Зөрчилгүй” санал дүгнэлттэй шалгагдаж, санхүүгийн тайлангийн аудитын шалгалтаар өгсөн зөвлөмжийг нэгтгэн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган цаашид анхаарах асуудлаар зөвлөмж боловсруулан харьяа нэгжүүдэд хүргүүлээ.
	8.7. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг.	Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 5, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг бүхий 5 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим систем www.shilendans.gov.mn болон байгууллагын цахим хуудас www.police.gov.mn , мэдээллийн самбарт хуулийн хугацаанд тухай бүрд нь байршуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн.

		<p>8 8. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл.</p>	<p>Энэ оны эхний 5 сарын байдлаар Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэд салбар зөвлөлийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан “Төрийн албаны тусгай болон мэргэжил олгох сургалтын элсэлтийн шалгалтыг зохион байгуулах ажлын хэсэг”-ийн гишүүн 60 алба хаагч, батлагдсан төлөвлөгөөний дагуу 2021 оны 1, 3 дугаар сард Увс, Архангай аймаг дахь цагдаагийн газар, Хар тамхитай тэмцэх газрын үйл ажиллагаанд явуулсан төлөвлөгөөт шалгалтын ажлын хэсгийн 19, нийт 79 алба хаагчаас ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлж гаргасан мэдэгдлийг бүртгэн хяналт тавьж ажилласан.</p>
<p>Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах</p>		<p>8.9. Цагдаагийн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох гэх мэт бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсанд байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах.</p>	<p>Гэрээт харуул хамгаалалтад хяналт тавих чиг үүргийг Бүртгэл хяналтын төвд хариуцуулсантай холбогдуулан Цагдаагийн байгууллагын www.police.gov.mn сайтад Бүртгэл хяналтын төв цэсэнд товч танилцуулгыг шинэчлэн, байгууллагын цахим хуудас www.license.police.gov.mn сайтад албаны үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл болон хууль тогтоомж, журмыг байршуулсан.</p> <p>“Төрийн үйлчилгээний операторын болон нэгдсэн портал” www.e-Mongolia.mn сайтын хэрэглэгчдэд зориулсан мэдээлэл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/292 дугаар тушаалаар баталсан “Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам”-д заасан тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх, үнэмлэх олгох, жолоодох эрх сэргээх, дуусгавар болохтой холбоотой мэдээллийг Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз болон Монголын Үндэсний радиогийн “Та замд явна уу” булангаар 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдөр иргэдэд хүргэсэн.</p> <p>Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн бүрдүүлэх материалын жагсаалт, хүн, хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх талаарх лавлагаа, тодорхойлолт олгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тайлбар, "Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам", тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх зөвшөөрөл, тээвэрлэх жолооч, техникийн шаардлага зэрэг цагдаагийн байгууллагаас олгодог зөвшөөрлийн талаарх мэдээллийг Цагдаагийн байгууллагын албан ёсны www.police.gov.mn цахим сайтад байршуулж, хэвлэл мэдээллийн 10 цахим сайтаар иргэд, олон нийтэд мэдээллийг түгээж, сурталчилж ажилласан.</p>
		<p>8.10. Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацаа.</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн А/292 дугаар тушаал баталсан “Тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам”, “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль”-ийн 11, 12, 15 дугаар</p>

			<p>зүйлд заасан ажил үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулахтай холбоотой мэдээлэл, Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагааны “Бүртгэлийн гэрчилгээ” шинээр авах, зөвшөөрөл сунгуулах тухай хүсэлтүүдийг “SAS” мэдээллийн нэгдсэн санд, тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх бүртгэл, зөвшөөрлийн нэгдсэн сан, тэсэрч тэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, жолоочийн бүртгэл, мэдээллийн “TPS” нэгдсэн цахим санд зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааны талаарх мэдээллийг байршуулсан.</p>
		<p>8.11. Ажилтнуудын хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээлэх.</p>	<p>Бүртгэл хяналтын төвийн угтах үйлчилгээний зааланд галт зэвсэг эзэмших, улсын хилээр нэвтрүүлэх, тэсэрч дэлбэрэх бодистой холбоотой тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах, “Тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам”-ын дагуу хугацаа дууссан болон шинээр зөвшөөрөл авах, Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагааны “Бүртгэлийн гэрчилгээ” шинээр авах, зөвшөөрөл сунгуулах хүсэлт хүлээн авах алба хаагчдын мэдээлэл болон бүрдүүлэх материалын жагсаалт, тэмдэгтийн хураамжийн талаарх мэдээллийг байршуулан иргэдэд үйлчилгээ үзүүлж байна.</p>
		<p>8.12. Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээлэх</p>	<p>Жолоодох эрх сэргээх сургалтын үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах ажлын хүрээнд мэдээллийн самбаруудыг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн 6 салбарын байранд байршуулсан.</p> <p>Улаанбаатар хотод тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх сургалтын үйл ажиллагаа явуулдаг 14 төрийн бус байгууллагын тэргүүнүүдтэй 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдөр уулзаж, үйл ажиллагааны өнөөгийн байдал, иргэд, олон нийтэд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийг сурталчлах, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллага, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудтай хамтран ажиллах, үр дүнг дүгнэх, тайлагнах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны Б/584 дүгээр тушаалаар баталсан “Тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх сургалтын хөтөлбөр”-ийг мөрдөж ажиллах, сургалт зохион байгуулахад гарч байгаа алдаа, дутагдал, анхаарах асуудлын талаар зөвлөмж хүргүүлсэн.</p>

<p>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>8.13. Цагдаагийн алба хаагчдад холбогдох авлига, ашиг сонирхол, сахилга ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг 24 цагийн хугацаанд тасралтгүй шуурхай хүлээн авах суурин телефон /126/ утсыг Цагдаагийн төв байгууллагын жижүүрт байрлуулж мэдээллийг харьяалах алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад шилжүүлэн хянан шалгах, хариуцлага хүлээлгэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.</p>	<p>Цагдаагийн төв байгууллагын жижүүрт тусгай дугаар/126/-ын утсыг 24 цагаар ажиллуулж цагдаагийн алба хаагчдад холбогдох авлига, ашиг сонирхол, сахилга ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч байна.</p> <p>2021 оны 5 сарын байдлаар /126/ тусгай дугаарын утсаар иргэн, хуулийн этгээдээс 206 мэдээлэл ирүүлснээс цагдаагийн алба хаагчдад холбогдох авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээлэл байхгүй, байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаа, сахилга, ёс зүйтэй холбоотой гомдол 118, талархал 47, санал 6 байна.</p>
	<p>8.14. Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдал /тушаал, захирамж/</p>	<p>Цагдаагийн төв байгууллагын даргад хуулиар эрх олгон баталсан хэм хэмжээний 12 акт болон ЦЕГ-ын даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-ийг тус тус Цагдаагийн ерөнхий газрын цахим хуудас /www.police.gov.mn/-ны “Хууль, эрх зүй” цэсний “ЦЕГ-ын даргын тушаал” дэд цэсэнд байршуулсан.</p> <p>Мөн цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2021 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны стратегийн зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тухай бүр байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэж байна.</p>
	<p>8.15. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, заавар</p>	<p>Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай Засгийн газрын 40 тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дангаар болон хамтран баталсан 68 тушаал, Цагдаагийн ерөнхий газрын даргын дангаар болон хамтран баталсан 52 тушаал, Улсын Ерөнхий прокурорын 19 тушаалын жагсаалтыг гаргаж, холбогдох эрх зүйн актуудад баяжилт хийж, тухай бүр цагдаагийн байгууллагын www.police.gov.mn, www.system.police.gov цахим хуудсанд тус тус байршуулж, мэдээллийг тухай бүр цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлсэн.</p>
	<p>8.16. Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн үнэ, тарифын талаарх мэдээллийг хууль эрх зүйн үндэслэл журмын хамт байршуулах</p>	<p>Цахим төлбөр тооцоонд шилжихтэй холбоотойгоор “www.e-Mongolia.mn” сайтын “Жолоодох эрх”, “Тээврийн хэрэгсэл” цэсэнд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан тэмдэгтийн хураамжийн талаарх мэдээллийг Цагдаагийн байгууллагын “www.police.gov.mn”, “www.license.police.gov.mn” сайтууд, facebook дэх “ЦЕГ-Бүртгэл хяналтын төв” нээлттэй цахим хаягт байршуулсан.</p>
	<p>8.17. Төсвийн орлого бүрдүүлэлт, хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд</p>	<p>Цагдаагийн байгууллагаас хуульд тогтоомжийн дагуу жолоодох эрхийн үнэмлэх, галт зэвсэгийн сургалтын болон эрүүлжүүлэх саатуулах байрны төлбөр, лавлагааны тэмдэгтийн хураамжийг</p>

	орсон өөрчлөлтийг цахим хуудсанд байршуулах	төсвийн орлогод төвлөрүүлж, үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.
Иргэдийн гаргасан өргөдөл /санал, мэдэгдэл/ гомдол, хүсэлтийг хүлээн авах, цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх, мэдээлэл өгөх, ил тод, нээлттэй суваг ажиллуулах	8.18. Цагдаагийн байгууллагын албан ёсны /service.police.gov.mn/ цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн гомдол мэдээллийг хүлээн авах, иргэний гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах албан тушаалтны нэр, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах	Цагдаагийн байгууллагын цахим хуудсаар дамжуулан complaints@police.gov.mn хаягаар иргэдээс өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч, цахим бүртгэл хөтлөн шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Цахим хуудсанд “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх хууль”-ийн зүйл заалтын мэдээлэл, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтний нэр цол, харилцах утасны дугаар, өргөдөл гомдол хүлээн авах цагийн хуваарь, гомдол гаргагчийн нэр, утасны дугаар, цахим шуудангийн хаягийн бүртгэлийг “complaints@police.gov.mn-д байршуулсан.
	8.20. Иргэн гаргасан өргөдөл, гомдлыг цахим хэлбэрээр хянах, ямар шатанд байгааг мэдээлэх нээлттэй суваг ажиллуулах.	Цагдаагийн байгууллагын complaints@police.gov.mn цахим хаягт ирүүлсэн гомдлыг өргөдөл, гомдол хариуцсан алба хаагч бүртгэн, ямар албан тушаалтанд шилжүүлсэн болон явц, шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг иргэний цахим шуудангийн хаягаар хүргэн ажиллаж байна.
Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	8.21. Цагдаагийн байгууллагын бүтэц зохион байгуулалт, нэршил өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлах, боловсронгуй болгох.	2021 оны эхний 5 сарын байдлаар шинээр бий болсон, чиг үүрэг өөрчлөгдсөн 174 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар батлуулсан.
Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	8.22. Сул орон тооны зар /тухай бүр шинэчилсэн/	Цагдаагийн байгууллагын албан ёсны “www.police.gov.mn” сайт, Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвийн фэйсбүүк пэйж хуудаст “Цагдаа”, “Цагдаа жолооч”, Дотоодын цэргийн “Харуулчин” мэргэжил олгох сургалтад суралцаж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагад ажиллахыг урьж байна”, “Дотоод хэргийн Их сургуулийн Ахлагчийн сургуулийн элсэлтийн шалгалтын нэгдсэн дүн гарлаа”, “Мэргэжил олгох сургалтын элсэлтийн шалгалтын хуваарьт өөрчлөлт орлоо” зэрэг мэдээлэл байршуулсныг 669.709 хүн үзэж, 796 хүнд таалагдаж, 119 хүн сэтгэгдэл үлдээж, 671 удаа бусадтай хуваалцсан байна.
	8.23. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам.	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны б/164 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа мөрдөж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А884 дугаартай тушаалаар байгуулсан “Бодлогын баримт бичгийг шинэчлэх ажлын хэсэг”-ээс төлөвлөгөө гарган ажиллаж байна.

		<p>8.24. Цагдаагийн албаны хүний нөөцийн ил тод байдлыг ханган ажлын байрны сонгон шалгаруулалтын мэдээллийг тухай бүр шинэчилж, иргэдийн танилцах боломжийг бүрдүүлэх.</p>	<p>Төрийн албаны зөвлөлд Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.1.3 дахь заалт, "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын 2.1, 2.3-т заасныг үндэслэн албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.</p> <p>Дээрх албан тушаалын сонгон шалгаруулалтын бүртгэл, нэмэлт шалгалт (тусгай бэлтгэл, бие бялдрын), хууль эрх зүйн мэдлэг, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, Монгол хэлний ярианы болон бичгийн, багаар ажиллах чадварын шалгалтыг зохион байгуулах зар мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн https://www.csc.gov.mn/ сайтад байрлуулсан.</p> <p>"Цагдаагийн мэргэжил олгох сургалтад суралцаж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагад ажиллахыг урьж байна" зарыг "Өдрийн сонин", "Өнөөдөр" сонинд тавьж, facebook цахим хуудсаар иргэдэд мэдээллийг хүргэсэн.</p>
--	--	---	---

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР